

**БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2019-2020 ОНЫ  
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**Бага, дунд боловсролын сургалтын байгууллага (байршил, өмчийн хэлбэр, ангилал)**

2019-2020 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 820 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрийн 80.7 хувь нь төрийн өмчийн, 19.3 хувь нь хувийн сургууль байна.

*Хүснэгт 1. Ерөнхий боловсролын сургуулийн тоо (өмчийн хэлбэр, ангиллаар)*

	Ерөнхий боловсролын сургууль							
	Бүгд	төрийн	хувийн	Бүгд	бага	дунд	ахлах	цогцолбор
<b>2015-2016</b>	<b>768</b>	636	132	<b>768</b>	62	118	538	50
<b>2016-2017</b>	<b>778</b>	645	133	<b>778</b>	69	117	542	50
<b>2017-2018</b>	<b>798</b>	652	146	<b>798</b>	74	116	562	46
<b>2018-2019</b>	<b>803</b>	656	147	<b>803</b>	80	115	563	45
<b>2019-2020</b>	<b>820</b>	662	158	<b>820</b>	78	113	584	45

2019-2020 оны хичээлийн жилд нийт сургуулийн 78 буюу 9.5 хувь нь бага сургууль, 113 буюу 13.8 хувь нь дунд сургууль, 584 буюу 71.2 хувь нь ахлах сургууль, 45 буюу 5.5 хувь нь цогцолбор сургуулийн ангилалд багтаж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад бага сургуулийн тоо 2-оор, дунд сургуулийн тоо 2-оор буурсан бол, ахлах сургуулийн тоо 1-ээр нэмэгдэж, цогцолбор сургуулийн тоо хэвээр байна.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 55 (8.3%) нь бага сургуулийн, 112 (16.9%) нь дунд сургуулийн, 455 (68.7%) нь ахлах сургууль, 40 (6.0%) нь цогцолбор сургуулийн;

Хувийн сургуулийн 23 (14.6%) нь бага сургуулийн, 1 (0.6%) нь дунд сургуулийн, 129 (81.6%) нь ахлах сургуулийн, 5 (3.2%) нь цогцолбор сургуулийн ангилалд тус тус багтаж сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.

*Хүснэгт 2. Ерөнхий боловсролын сургууль (байршил, хэв шинжээр)*

	Ерөнхий боловсролын сургууль								
	Бүгд	хот	хөдөө	Бүгд	ердийн	мэргэ жлийн	гүнзгий рүүлсэн	тусгай	олон улсын хөтөлбөр
<b>2015-2016</b>	<b>768</b>	215	553	<b>768</b>	662	14	81	6	5
<b>2016-2017</b>	<b>778</b>	226	552	<b>778</b>	684	15	66	6	7
<b>2017-2018</b>	<b>798</b>	241	557	<b>798</b>	705	16	63	6	8
<b>2018-2019</b>	<b>803</b>	245	558	<b>803</b>	708	15	67	6	7
<b>2019-2020</b>	<b>820</b>	258	562	<b>820</b>	721	15	70	6	8

Нийт сургуулийн 68.5 хувь буюу 562 нь хөдөөд, 31.5 хувь буюу 258 нь нийслэлд сургалтын ажил эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 721 буюу 87.9 хувь нь ердийн, 15 буюу 1.8 хувь нь мэргэжлийн, 70 буюу 8.5 хувь нь гүнзгийрүүлсэн, 6 буюу 0.7 хувь нь тусгай, 8 буюу 1.0 хувь нь олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулж байна. Өмнөх жилээс ердийн, гүнзгийрүүлсэн болон олон улсын хөтөлбөртэй сургуулийн тоо өссөн бол мэргэжлийн болон тусгай сургуулийн тоо хэвээр байна.

**Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, бүлэг дүүргэлт (өдрийн анги)**

Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 21.8 мянган бүлэгт 640.5 мянган суралцагчид суралцаж байна. Нийт бүлгийн 19.4 мянга

буюу 89.1 хувь нь төрийн өмчийн, 2.4 мянга буюу 10.9 хувь нь хувийн сургуульд ногдож байгаа бөгөөд нийт бүлгийн 49.6 хувийг *бага*, 33.0 хувийг *дунд*, 17.4 хувийг *ахлах ангийн* бүлэг тус тус бүрдүүлж байна. Бүлгийн тоо өнгөрсөн хичээлийн жилээс 5.9 хувь (үүнээс бага анги 1.5 пунктээр буурсан бол, дунд анги 0.2, ахлах анги 1.3 пунктээр тус тус өссөн)-иар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 3. Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг (өдрийн анги, ээлж, тоогоор)*

	Бүлгийн тоо							
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Бүгд	1-р ээлж	2-р ээлж	3-р ээлж
2015-2016	19,304	9,554	5,429	4,321	19,304	12,058	7,071	175
2016-2017	19,677	9,795	6,171	3,711	19,677	12,215	7,238	224
2017-2018	20,211	10,214	6,553	3,444	20,211	12,705	7,320	186
2018-2019	20,574	10,518	6,746	3,310	20,574	13,240	7,122	212
2019-2020	21,794	10,811	7,184	3,799	21,794	13,991	7,794	9

Ерөнхий боловсролын сургуулийн нийт бүлгийн 64.2 хувь нь нэгдүгээр ээлжид, 35.8 хувь нь хоёрдугаар ээлжид, 0.04 хувь нь гуравдугаар ээлжид хичээллэж байна.

*Хүснэгт 4. Ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжид хичээллэж байгаа бүлэг, хүүхэд (өдрийн анги, тоогоор)*

	Бүлгийн тоо				Хүүхдийн тоо			
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Бүгд	Бага	Дунд	Ахлах
2015-2016	175	175	-	-	6,311	6,311	-	-
2016-2017	224	218	6	-	8,755	8,566	189	-
2017-2018	186	159	27	-	7,335	6,412	923	-
2018-2019	212	181	25	6	8,451	7,511	786	154
2019-2020	9	4	3	2	308	150	115	43

Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд 2 сургуулийн 9 бүлэгт 308 суралцагч 3-р ээлжид хичээллэж байна. Эдгээр 3-р ээлжийн бүлгийн 44.4 хувь нь бага ангийн, 33.3 хувь нь дунд ангийн, 22.3 хувь нь ахлах ангийн бүлэг байна.


*Хүснэгт 5. Ерөнхий боловсролын сургуулийн 3-р ээлжид хичээллэж байгаа бүлэг, хүүхэд (өдрийн анги, тоогоор)*

Он		2015-2016 он			2016-2017 он			2017-2018 он			2018-2019 он			2019-2020 он		
Үзүүлэлт	Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд	Байршил		Бүгд Хот	Байршил		Бүгд	Байршил		
		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө		Хот	Хөдөө				
Сургуулийн тоо		24	23	1	32	31	1	25	22	3	28	23	5	2	1	1
III ээлж	Бүлэг	175	174	1	224	222	2	186	173	13	212	188	24	9	7	2
	Хүүхдийн тоо	6,311	6,278	3	8,755	8,706	49	7,335	6,932	403	8,451	7,743	708	308	265	43

Говь-алтай аймгийн ерөнхий боловсролын Хантайшир-эрдэм цогцолбор сургууль, Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 133-р сургуулиуд тус тус 3 ээлжээр хичээллэж байна. Сүүлийн 10 жилийн байдлаар 20-35 сургууль жил бүр 3-р ээлжээр хичээллэж

байсныг 2019-2020 онд 2 сургуулийн түвшинд хүргэсэн нь төр засгаас ихээхэн анхаарал хандуулж бүтээн байгуулалтыг хийсэн байна.

График 1 Бүлэг дүүргэлт (түвшин, улсын хэмжээнд, оноор)



Улсын хэмжээнд бүлэг дүүргэлт 29.4 байгаа нь өмнөх жилээс 0.6 пунктээр, үүнээс төрийн өмчийн сургуульд 30.6 байгаа нь өмнөх жилээс 0.7 пунктээр, хувийн сургуульд 19.8 байгаа нь өмнөх жилээс 0.9 пунктээр тус тус өссөн байна.

Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс их буюу 38.0-54.4-тэй нэр бүхий нийслэлийн 35, аймгийн 6 сургууль үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 6. Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс их ерөнхий боловсролын сургуулиуд (Сүүлийн хоёр жилээр)

№	Аймаг, нийслэл, дүүрэг	Сургуулийн нэр	2018-2019 он	2019-2020 он		
1	Улаанбаатар	23-р сургууль	54.4	53.6 ↓		
2		Чингэлтэй дүүрэг	5-р сургууль	46.2	45.1 ↓	
3			24-р сургууль	42.9	42.5 ↓	
4			50-р сургууль	38.4	39.4 ↑	
6			Сүхбаатар дүүрэг	1-р сургууль	53.9	50.7 ↓
7		3-р сургууль		47.3	47.7 ↑	
8		31-р сургууль		42.6	43.6 ↑	
9		2-р сургууль		41.5	41.9 ↑	
10		45-р сургууль		38.4	40.9 ↑	
11		Эрдмийн хөтөч цогцолбор	38.0	38.5 ↑		
12		Хан-уул дүүрэг	18-р сургууль	50.8	51.0 ↑	
13			52-р сургууль	45.2	45.5 ↑	
14			Буянт-ухаа цогцолбор сургууль	42.9	40.8 ↓	
15			114-р сургууль	33.0	44.1 ↑	
16			115-р сургууль	34.8	42.9 ↑	
17			118-р сургууль	39.2	38.6 ↓	
18			Баянзүрх дүүрэг	84-р сургууль	46.7	46.5 ↓
19				33-р сургууль	44.6	43.8 ↓
20				44-р сургууль	41.3	43.9 ↑
21				111-р сургууль	42.9	41.6 ↓
22				14-р сургууль	41.8	44.4 ↑
23				53-р сургууль	38.1	41.3 ↑
24		Шавь цогцолбор		39.1	40.9 ↑	

25			113-р сургууль		38.5 ↑
26			97-р сургууль	37.3	38.3 ↑
27		Баянгол дүүрэг	Эрдмийн өргөө цогцолбор сургууль	42.7	43.5 ↑
28			20-р сургууль	42.3	43.6 ↑
29			93-р сургууль	42.5	43.0 ↑
30			Оюуны-ундраа цогцолбор сургууль	39.9	39.5 ↓
31			38-р сургууль	42.7	42.7 -
33			12-р сургууль	44.6	47.1 ↑
34		Сонгинохайрхан дүүрэг	104-р сургууль	39.1	40.1 ↑
35			122-р сургууль	42.2	43.3 ↑
36			62-р сургууль	40.7	42.2 ↑
37			65-р сургууль	36.5	39.3 ↑
38			Ирээдүй цогцолбор сургууль	39.1	39.1 -
35			42-р сургууль	37.4	38.3 ↑
36	Дархан-уул аймаг		Оюуны ирээдүй цогцолбор	39.2	40.1 ↑
37	Хөвсгөл аймаг		Эрдмийн далай цогцолбор	38.6	39.5 ↑
38	Орхон аймаг		14-р сургууль	37.4	39.1 ↑
39			5-р сургууль	38.3	38.4 ↑
40	Өвөрхангай		Арвайхээр-1	33.8	38.0 ↑
41	Баянхонгор		Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн цогцолбор		38.9 ↑

Өмнөх жилээс 10 сургуулийн бүлэг дүүргэлт буурсан, 2 сургууль хэвээр байгаа бол бусад сургуулийн бүлэг дүүргэлт өссөн байна. Энэ нь шинээр элсэгч 4.6 мянгаар, нийт суралцагч 47.3 мянгаар нэмэгдсэнтэй холбоотой юм.

### Суралцагчид

2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 646.8 мянган (өдрөөр 640,449, оройгоор 88, эчнээгээр 123, дүйцсэн хөтөлбөрөөр 6,179) суралцагч өдөр, орой, эчнээ, дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж байна. Насан туршийн боловсролын төвд 6,179 хүүхэд дүйцсэн хэлбэрээр суралцаж байна. Суралцагчдын тоо өнгөрсөн хичээлийн жилээс 19,234-өөр, үүнээс өдрөөр суралцагч 20,398-аар тус тус өссөн бол, эчнээгээр суралцагч 131-ээр, оройгоор суралцагч 3-аар, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч 1,030-аар тус тус буурсан байна.

Хүснэгт 7. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид (сургалтын хэлбэрээр)

	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид				
	Нийт	өдөр	орой	эчнээ	дүйцсэн
2015-2016	546,215	535,055	244	723	10,193
2016-2017	561,693	551,953	177	447	9,116
2017-2018	581,160	572,752	111	350	7,947
2018-2019	600,384	593,150	108	219	6,917
2019-2020	646,839	640,449	88	123	6,179

Өдрөөр суралцагчдын 92.7 хувь нь төрийн өмчийн сургуульд, 7.3 хувь нь хувийн сургуульд суралцаж байна (Хүснэгт 8). Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад бага ангийн суралцагчдын тоо 4.6, дунд ангийн суралцагчдын тоо 8.4, ахлах ангийн суралцагчдын тоо 15.4 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 8. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (анги, өмчийн хэлбэрээр)

	Суралцагчдын тоо						
	Бүгд	Төрийн	Хувийн	Бүгд	Бага	Дунд	Ахлах
2015-2016	535,055	504,070	30,985	535,055	271,687	147,031	116,337
2016-2017	551,953	520,201	31,752	551,953	288,345	167,364	96,244
2017-2018	572,752	537,740	35,012	572,752	309,355	176,210	87,187
2018-2019	593,150	553,562	39,588	593,150	327,019	184,017	82,114
2019-2020	640,449	593,438	47,011	640,449	342,634	200,806	97,009

Суралцагчдын 60.3 хувь буюу 386.5 мянга нь нэгдүгээр ээлжид, 39.6 хувь буюу 253.7 мянга нь хоёрдугаар ээлжид, 0.05 хувь буюу 308 суралцагч гуравдугаар ээлжид хичээллэж байна. Гуравдугаар ээлжинд хичээллэж байгаа хүүхдийн тоо өмнөх оноос **27.4 дахин** буурчээ.

### Суралцагчдын хүйсийн харьцаа

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 50.0 хувийг охид, 50.0 хувийг хөвгүүд бүрдүүлж байна. Энэ харьцаа төрийн өмчийн сургуульд мөн адил 50.0:50.0, хувийн сургуульд 49.1:50.9-тай байна. Бага ангийн нийт суралцагчдын 48.9 хувь, дунд ангийн 49.5 хувь, ахлах ангийн 54.7 хувийг охид эзэлж байна. (Хүснэгт 9). Хүйсийн ялгааны индекс 1.0 байна. Өөрөөр хэлбэл, 100 эрэгтэй сурагчид 100 эмэгтэй сурагч ногдож байна гэсэн үг.

Хүснэгт 9. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид хүйсээр (ангиар)

Үзүүлэлт	бага		дунд		ахлах	
	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
2015-2016	49.0%	51.0%	49.3%	50.7%	54.8%	45.2%
2016-2017	49.0%	51.0%	49.7%	50.3%	54.6%	45.4%
2017-2018	48.9%	51.1%	49.6%	50.4%	54.3%	45.7%
2018-2019	48.9%	51.1%	49.7%	50.3%	53.7%	46.3%
2019-2020	48.9%	51.1%	49.5%	50.5%	54.7%	45.3%

### Суралцагчдын насны ангилал

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын 53.4 хувийг 6-10 настай суралцагч буюу бага боловсрол эзэмших насны суралцагчид, 30.9 хувийг 11-14 настай, 14.9 хувийг 15-17 настай, 0.8 хувийг 18 ба түүнээс дээш настай суралцагч бүрдүүлж байна. Сургуулийн эрт элсэлт бүртгэгдээгүй, 15-17 настай суралцагчид 2.1, 18 ба түүнээс дээш настай суралцагчдын тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол 6-10 настай суралцагчдын тоо 1.2, 11-14 настай суралцагчид 1.1 пунктээр тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (насаар)

Он	Суралцагчдын тоо						
	Бүгд	5 хүртэлх нас	6 нас	7-10 нас	11-14 нас	15-17 нас	18 ба түүнээс дээш
2015-2016	535,055	2,490	63,449	202,444	163,387	97,996	5,289
2016-2017	551,953	1,672	59,082	225,638	164,260	97,724	3,577
2017-2018	572,752	383	65,359	242,577	167,279	94,179	2,975
2018-2019	593,150	-	69,139	257,257	179,474	85,085	2,195
2019-2020	640,449	-	73,854	268,106	198,162	95,157	5,170

Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 6,053 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Эдгээр хүүхдүүд нь нийт суралцагчдын 0.9 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 11. ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо*

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс					
		Харааны	Сонсголын	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтэний	Хавсарсан
<b>2015-2016</b>	<b>9,143</b>	3,086	1,053	1,387	766	1,374	1,477
<b>2016-2017</b>	<b>8,362</b>	2,632	951	1,286	881	1,252	1,360
<b>2017-2018</b>	<b>7,279</b>	2,102	828	1,136	788	1,091	1,334
<b>2018-2019</b>	<b>6,518</b>	1,638	712	958	931	956	1,323
<b>2019-2020</b>	<b>6,053</b>	1,358	633	857	885	894	1,426

### **Нэгдүгээр ангид шинээр элсэгч**

2019-2020 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид суралцагчдын 99.7 хувь (76,892)-ийг шинээр элссэн суралцагч бүрдүүлж байгаа нь өмнөх оноос 0.1 пунктээр өссөн байна. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 6.4 хувиар өссөн бөгөөд суралцагчдын 92.4 хувь нь төрийн өмчийн, 7.6 хувь нь хувийн сургуульд элсжээ.

*Хүснэгт 12. Нэгдүгээр ангид шинээр элссэн суралцагчид (өмчийн хэлбэрээр)*

Хичээлийн жил	Шинээр элсэгч	Үүнээс		Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан	Шинээр элсэгчдээс сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Нийт элсэгчдээс шинээр элсэгчдийн эзлэх хувь
		Төрийн өмчийн сургуульд	Хувийн сургуульд			
<b>2016-2017</b>	62,000	58,687	3,313	42,315	68.3	99.6
<b>2017-2018</b>	67,974	64,148	3,826	43,932	64.6	99.6
<b>2018-2019</b>	72,247	67,385	4,862	50,932	70.5	99.6
<b>2019-2020</b>	76,892	71,081	5,811	61,702	80.2	99.7

Элсэгчдийн 95.4 хувийг 6 настай суралцагчид буюу өмнөх оноос 1.3 пунктээр өссөн байна.

Нийт элсэгчдийн 80.2 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан бөгөөд өмнөх оноос 9.7 пунктээр өссөн бол элсэгчдийн 19.8 хувь нь сургуульд элсэхийн өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй байна.

### **Ажиллагчид болон багшлах хүний хүчин**

Ерөнхий боловсролын сургуульд 51,5 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 89.8 хувь нь төрийн өмчийн сургуульд, 10.2 хувь нь хувийн сургуульд ажиллаж байна. Ажиллагчдын тоо өмнөх хичээлийн жилээс 4.3 хувь буюу 2,109 (төрийн өмчийн сургууль 1,443-аар, хувийн сургууль 666)–өөр нэмэгдсэн.

*Хүснэгт 13. Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчид*

Хичээлийн жил	Ажиллагчдын тоо	Үүнээс		Төрийн өмч	
		Төрийн өмч	Хувийн өмч	Хот	Хөдөө
<b>2015-2016</b>	46,791	42,936	3,855	12,645	30,291
<b>2016-2017</b>	47,168	43,261	3,907	13,246	30,015
<b>2017-2018</b>	47,991	43,754	4,237	13,263	30,491
<b>2018-2019</b>	49,441	44,845	4,596	14,142	30,703

<b>2019-2020</b>	51,550	46,288	5,262	14,881	31,407
------------------	--------	--------	-------	--------	--------

Ерөнхий боловсролын сургуульд 32,1 мянган багш ажиллаж байгаагийн 89.7 хувь нь төрийн өмчийн сургуульд, 10.3 хувь нь хувийн сургуульд ногдож байна. Багшийн тоо өмнөх хичээлийн жилээс 5.5 хувь буюу 1,674 (төрийн өмчийн сургууль 1,142-оор, хувийн сургууль 522)–өөр нэмэгдсэн. Нийт багш нарын 26,149 буюу 81.5 хувь нь эмэгтэй, 18.5 хувь нь эрэгтэй бол, нийт багшийн 34.4 хувь буюу 11.0 мянга нь бага анги, 65.6 хувь буюу 21.0 мянга нь дунд, ахлах ангийн багш нар байна.

*Хүснэгт 14. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш*

	<b>Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш</b>						
	Нийт	бага	дунд	ахлах	Нийт	Төрийн	Хувийн
<b>2015-2016</b>	<b>28,490</b>	<b>9,877</b>	<b>11,454</b>	<b>7,159</b>	<b>28,490</b>	<b>26,209</b>	<b>2,281</b>
<b>2016-2017</b>	<b>28,889</b>	<b>9,976</b>	<b>11,708</b>	<b>7,205</b>	<b>28,889</b>	<b>26,527</b>	<b>2,362</b>
<b>2017-2018</b>	<b>29,242</b>	<b>10,238</b>	<b>11,960</b>	<b>7,044</b>	<b>29,242</b>	<b>26,742</b>	<b>2,500</b>
<b>2018-2019</b>	<b>30,411</b>	<b>10,736</b>	<b>12,670</b>	<b>7,005</b>	<b>30,411</b>	<b>27,615</b>	<b>2,796</b>
<b>2019-2020</b>	<b>32,085</b>	<b>11,030</b>	<b>13,703</b>	<b>7,352</b>	<b>32,085</b>	<b>28,767</b>	<b>3,318</b>

#### **Багш нарын боловсролын түвшин, насны ангилал, ажилласан жил**

Нийт багш нарын 0.06 хувийг докторын зэрэгтэй, 14.9 хувийг магистрын зэрэгтэй, 73.9 хувийг бакалавр, 8.5 хувийг дипломын боловсролтой багш эзэлж байна. (Хүснэгт 15). Өмнөх жилээс магистрийн зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.6 пунктээр, бакалаврын зэрэгтэй багш 0.6 пунктээр тус тус өссөн бол докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.04, дипломын боловсролтой багшийн эзлэх хувь 1.0 пунктээр тус тус буурсан байна.

*Хүснэгт 15. Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа үндсэн багшийн боловсролын түвшин*

Хичээлийн жил	Мэргэжлийн багшийн эзлэх хувь <sup>1</sup>	Үүнээс:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
<b>2015-2016</b>	<b>98.9</b>	<b>22</b>	<b>4,085</b>	<b>20,142</b>	<b>3,916</b>	<b>325</b>
<b>2016-2017</b>	<b>98.6</b>	<b>23</b>	<b>3,983</b>	<b>20,949</b>	<b>3,530</b>	<b>404</b>
<b>2017-2018</b>	<b>97.0</b>	<b>23</b>	<b>4,034</b>	<b>21,185</b>	<b>3,131</b>	<b>869</b>
<b>2018-2019</b>	<b>97.2</b>	<b>19</b>	<b>4,347</b>	<b>22,301</b>	<b>2,901</b>	<b>843</b>
<b>2019-2020</b>	<b>97.3</b>	<b>18</b>	<b>4,767</b>	<b>23,722</b>	<b>2,721</b>	<b>857</b>

Багш нарын 27.8 хувь нь 30 хүртэл насны, 35.4 хувь нь 30-39 насны, 24.4 хувь нь 40-49 насны, 11.2 хувь нь 50-59 насны, 1.2 хувь 60 ба түүнээс дээш насны багш нар байна. (Хүснэгт 16). Өмнөх жилээс 30-39 насны багшийн эзлэх хувь 0.1, 40-49 насны багшийн эзлэх хувь 0.3, 60 ба түүнээс дээш насны багшийн эзлэх хувь 0.3 пунктээр өссөн бол тус тус өссөн бол, 30 хүртэл насны багшийн эзлэх хувь 0.5, 50-59 насны багшийн эзлэх хувь 0.2 пунктээр тус тус буурсан байна.

*Хүснэгт 16. Багш нарын нас (насны ангилалаар)*

	<b>30 хүртэл</b>	<b>30-39</b>	<b>40-49</b>	<b>50-59</b>	<b>60 ба түүнээс дээш</b>
<b>2015-2016</b>	8,469	10,277	6,056	3,515	173
<b>2016-2017</b>	8,378	10,406	6,520	3,389	196
<b>2017-2018</b>	8,331	10,526	6,807	3,365	213
<b>2018-2019</b>	8,606	10,741	7,317	3,462	285

<sup>1</sup> Мэргэжлийн багшийн эзлэх хувь -Дипломоос дээш боловсролтой багшийн хувь

<b>2019-2020</b>	8,912	11,361	7,820	3,607	385
------------------	-------	--------	-------	-------	-----

Багш нарын ажилласан жил буюу ажлын туршлагыг авч үзэхэд нийт багш нарын 6.5 хувь нь анхны жилдээ, 25.9 хувь нь 1-5 жил, 24.0 хувь нь 6-10 жил, 16.5 хувь нь 11-15 жил, 10.4 хувь нь 16-20, 5.4 хувь нь 21-25, 11.3 хувь нь 25-аас дээш жил ажиллаж байна. (Хүснэгт 17).

Өмнөх жилээс анхны жилдээ ажиллаж байгаа багшийн эзлэх хувь 0.5, 6-10 жил ажиллаж буй багшийн эзлэх хувь 5.1, 11-15 жил ажиллаж буй багшийн эзлэх хувь 0.6, 16-20 жил ажилласан багшийн эзлэх хувь 0.3, 21-25 жил ажиллаж байгаа багшийн эзлэх хувь 0.3 пунктээр тус тус өссөн бол, 1-5 жил ажиллаж буй багшийн эзлэх хувь 5.9 пунктээр буурч, 25-аас дээш ажиллаж буй багшийн эзлэх хувь хэвээр байна.

Нийт багшийн 52.9 хувь нь 10 хүртэлх жил ажилласан багш нар байна.

*Хүснэгт 17. Багш нарын ажлын туршлага (ажилласан жилээр)*

	Ажилласан жил						
	Анхны жилдээ	1-5 жил	6-10 жил	11-15 жил	16-20 жил	21-25 жил	25-аас дээш жил
<b>2015-2016</b>	2,110	8,869	5,740	4,785	2,321	1,396	3,269
<b>2016-2017</b>	1,675	9,405	5,892	4,348	2,669	1,420	3,480
<b>2017-2018</b>	1,732	9,287	5,866	4,576	2,900	1,446	3,435
<b>2018-2019</b>	1,838	9,919	5,752	4,825	3,082	1,562	3,433
<b>2019-2020</b>	2,072	8,296	7,705	5,307	3,348	1,733	3,624

Багш нарын 43.0 хувь нь мэргэжлийн зэрэгтэй тэдгээрийн 1.5 хувийг зөвлөх, 31.2 хувийг тэргүүлэх, 67.3 хувийг заах аргач зэрэгтэй багш бүрдүүлж байна. Өмнөх жилээс зэрэгтэй багшийн эзлэх хувь 8.0 пунктээр өссөн бол, зөвлөх зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.6, тэргүүлэх зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.9 пунктээр тус тус өссөн бол, заах аргач зэрэгтэй багшийн эзлэх хувь 0.7 пунктээр буурсан байна.